



ӨМНӨГОВЬ АЙМАГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/44

Даланзадгад

Түр журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хууль, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавирус халдвар /КОВИД-19/-ыг гэрээр тусгаарлан эмчлэх болон эрэмбэлэн ангилж больницоор хэвтэн эмчлэхтэй холбоотой “Эмнэлгийн тусламж үйлчилгээг зохицуулах түр журам” –ийг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын дарга эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. “Эмнэлгийн тусламж үйлчилгээг зохицуулах түр журам”-ын хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга /М.Цэндсүрэн/, Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга /Ж.Отгонбайгал/, Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга /Б.Мидэрсүрэн/, Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга /М.Булганчимэг/ нарт тус тус даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ӨРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

